


**УЛСЫН ХИЛЭЭР ХАР ТАМХИ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛЛӨХ
МАНСУУРУУЛАХ БОДИС НЭВТРҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ НЬ**

**PREVENTION OF SMUGGLING OF DRUGS AND PSYCHOACTIVE
SUBSTANCES ACROSS STATE BORDERS**



Б.Ням-Очир

Дотоод хэргийн их сургуулийн

Хилийн албаны сургуулийн

Хилийн албаны тэнхимийн ахлах багш, дэд хурандаа

Товч утга: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг улсын хилээр нэвтрүүлэхгүй байх, хилийн хяналтын байгууллагын хяналтыг сайжруулах арга замын талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үгс: Улсын хил, хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис

Abstract: Prevent smuggling of drugs and psychoactive substances across state borders and improve the inspection of border control institutions.

Keywords: State border, drugs, psychoactive substances.

Судалгааны зорилго нь мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэг зөрчил сүүлийн жилүүдэд монгол улсад их гарах болсон нь хилийн боомтод ажиллаж байгаа хилийн хяналтын байгууллагын алба хаагчдыг энэ чиглэлд мэргэшүүлж сурган анхаарал хандуулж ажиллах шаардлага тулгарч байна.

Мансууруулах бодис гэж юу вэ?

“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис”-ын тодорхойлолтыг хууль зүй, анагаах ухаан, химийн зэрэг шинжлэх ухаануудын тус тусын тодорхой шалгууруудын үндсэн дээр гаргаж болдог.

Наркологи буюу мансуурал судлалын үүднээс авч үзвэл бүх мансууруулах бодис сэтгэцэд нөлөөт бодис багтана. Мансууруулах бодисын тоонд бидний нэрлэж заншсанаар хар тамхи буюу опиумын гаралтай мансууруулах бодисууд мөн ордог. Хар тамхи гэдэг нь

опиумуудад оноож өгсөн хар ярианы хэллэг бөгөөд албан ёсны баримт бичигт хэрэглэгдэх шинжлэх ухааны нэр томъёо биш юм.

Хүн амьдралдаа ямар нэг таашаал авахын тулд тодорхой нэг зүйлийг хийж, бүтээж, түүний төлөө хичээл зүтгэл гаргаж байж тэрхүү таашаалаа хүртдэг бол мансууруулах бодис нь энэ үйл явцыг эвдэж, ямар ч зүйл хийлгүйгээр дээд таашаал авч буй мэт мэдрэмж төрүүлдэг байна. Хар тамхи буюу narcotics нь “narcosis” гэх Грек үгээс гаралтай ба хөдөлгөөнгүй болон, нойронд автах, саажих гэсэн агуулгатай.

Хар тамхи ба Монгол улс

НҮБ-ын дэргэдэх Дэлхийн хар тамхитай тэмцэх алба 2010 онд Монгол Улсыг хар тамхи, мансууруулагч бодис тээвэрлэгч орон гэж үзэж байсан бол дөрвөн жилийн дараа хэрэглэгч орон хэмээн үзжээ. Ингэхдээ химийн аргаар гаргаж авсан сэргээшийн төрлийн синтетик бодисын хэрэглээ нэмэгдэх хандлагатай орон гэж тодотгожээ. Монгол улсад каннабис буюу олсны ургамлын байгалийн тархац их учраас каннабисын хэрэглэгч ихтэй орон гэж бас дүгнэсэн. Энэ дүгнэлт нь дараах судалгаанаас батлагдаж байна.

Судалгаанд оролцогчид, хугацаа, хамрах хүрээ

Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан дүүрэг, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн 1067 хүүхдийг хамруулан 2020 оны 10 дугаар сарын 23-наас 11 дүгээр сарын 26-ны хооронд тест болон ярилцлагын аргаар авсан судалгааг статистикийн SPSS программаар боловсруулж, дүгнэлт хийж нэгтгэсэн. Үүнд:

Судалгааны нэгтгэсэн үр дүн




График 1





График 2



/график 2/

Судалгаанд орон нутаг болон нийслэлийн нийт 1067 сурагч оролцсоноос 529 нь эрэгтэй, 538 нь эмэгтэй сурагч байна. /график 1/ Үүнээс 7 дугаар ангийн 60 хүүхэд, 8 дугаар ангийн 157 хүүхэд, 9 дүгээр ангийн 215 хүүхэд, 10 дугаар ангийн 243 хүүхэд, 11 дүгээр ангийн 189 хүүхэд, 12 дугаар ангийн 203 хүүхэд оролцсон байна.

Судалгаанд оролцогчдын хувьд энэ төрлийн бодисын талаар ер нь сонсдог 37%, заримдаа сонсдог 41%, маш их сонсдог 18% бол огт сонсоогүй 4% байна. ЕБС-ийн сурагчдын 96% нь мансууруулах бодисын талаар мэдээлэлтэй байна /График 3/. Судалгаанд оролцогчдын 28% нь мансууруулах бодисын талаарх мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернэт, 15% сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз нөхдөөс мэдээлэл авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй байна.




Судалгаанд оролцогчдын 44% нь уг бодисын 1-3 төрөл, 21% нь 3-5 төрлийг мэднэ, 20% нь огт мэдэхгүй, 5% нь 5-8 төрөл, 10% нь 8-аас дээш төрлийг тус тус мэднэ гэсэн байна.

Судалгаанд оролцогчдын 74% нь мансууруулах бодис огт




Мансууруулах, сэтгэгцэд нөлөөт бодисыг хэрэглэж буй аргууд.



хэрэглэж байгаагүй, 13% нь ганц удаа хэрэглэж байсан, 2% нь хааяа хэрэглэдэг гэсэн бол 11% нь олон удаа хэрэглэж байсан гэсэн байна.

Мансууруулах, сэтгэгцэд нөлөөт бодис худалдан авч буй байдал



Дээрх судалгаанд оролцсон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хар тамхи, мансууруулах бодисын талаар тодорхой мэдээлэлтэй, хэрэглэж байгаа, хэрэглэж үзсэн байгаа нь эцэг эх, сурган хүмүүжүүлэгч нар нь анхаарах, хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагууд гарч байгаа нь харагдаж байна.

Хилийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын ажиллагаа:

Хар тамхи мансууруулах бодисын 40-50 хувь нь хилийн боомтуудаар нэвтэрдэг гэсэн судалгаа байдаг.

Монгол улсын хувьд 2016-2020 онд улсын хилээр хар тамхи мансууруулах бодистой холбоотой 11 үйлдлийг таслан зогсоож 15,3 кг бодис хурааж авсан.

Монгол улсын томоохон боомтууд болох Чингис хаан, Замын үүд, Алтанбулаг боомтууд нь гол гарц чиглэлүүд болоод байгаа бөгөөд сүүлийн үед жижиг хөгжиж эхэлж байгаа боомтууд руу хар тамхины наймаачид бүлэглэлүүд үйл ажиллагаагаа чиглүүлж байгаа мэдээлэлтэй байна.

Хөгжиж эхэлж байгаа жижиг хилийн боомтууд дээр хар тамхи, мансууруулах бодис илрүүлэх техник тоног төхөөрөмж дутагдалтай, хяналт шалгалт сул, мэргэшсэн ажилтан дутмаг, байгаа зэрэг нь сул тал болж байна.

Сүүлийн үед хар тамхийг маш бага граммаар зөөж тээвэрлэж байгаа нь зарим техник технологиор илрүүлэх боломжгүй байна. Ер нь 100 хувь багажид найддаггүй бөгөөд алба хаагч буюу хүнийг мэргэшүүлж, техник технологийн дэвшлийг хослуулан хэрэглэвэл уг зөрчлийг таслан зогсоох, илрүүлэх боломжтой.

Хар тамхи мансууруулах бодисууд нь цаг үеэ даган шинэчлэгдэн өөрчлөгдөж энгийн хүний нүдээр хараад таних ямар ч боломжгүй болж байгаа зэрэг нь илрүүлэхэд ихээхэн хүндрэлтэй байна.

Хөрш зэргэлдээ улс орнууд бодлогоор хилийн боомтод ажиллаж байгаа болон хууль хяналтын байгууллагын алба хаагчдад нэгдсэн сургалт зохион байгуулах хэлбэрээр мэдлэг олгож байна.

Дүгнэлт:

1.Судалгаанаас үзэхэд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид нь хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодисын талаарх мэдээлэлтэй, сонссон, харсан, хэрэглэж үзсэн, хэрэглэж үзэх юмсан гэсэн бодолтой явж байгаа нь монгол улсад энэ төрлийн бодис хяналтгүй зарагдаж байгаа бөгөөд хяналт тавих, урьдчилан сэргийлэх ажил хангалтгүй явагдаж байна.

2.Монгол улсад хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн иргэдэд хүлээлгэх хуулийн хариуцлага нь олон улсын хууль эрх зүйтэй харьцуулахад харьцангуй хөнгөн ял шийтгэл ноогдуулдаг.

3.Хар тамхи мансууруулах бодисыг бусад улс орнуудаас нууцаар тээвэрлэн хилийн боомтуудаар нэвтрүүлж, Монгол улсын иргэдэд олон нэр төрлийн бодисыг дамжуулан зарж ашиг олдог байж болзошгүй гэж дүгнэж байна.

Санал:

1.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын программд анхаарч хар тамхи мансууруулах бодисын хор хөнөөлийн талаар тодорхой хэмжээний үнэн зөв бодит мэдээллийг өгч урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.Монгол улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх тухай хууль эрх зүйг шинэчлэн боловсруулж, хүлээлгэх хариуцлагыг чангатгах.

3.Улс эх орныхоо үүдэн хил хязгаарыг хамгаалж байгаа хилийн хяналтын байгууллагын алба хаагчдад хар тамхийг таньж илрүүлэх, хууль зүйн дагуу шийдвэрлэх арга зүйн талаар сургалт зохион байгуулж явуулах, хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлсэн алба хаагчдыг хуулийн хамгаалалтад авах арга хэмжээг зохион байгуулснаар улс эх орны үндэсний аюулгүй байдал хангагдан хэмээн үзэж байна.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр. УБ 2017 он
2. “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” криминологи судалгааны тайлан. УБ 2020 он
3. Монгол улс дахь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодистой холбоотой гэмт хэрэгт ноогдуулж буй ял шийтгэл, тулгамдаж буй асуудал /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Нийслэлийн шүүх, Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ, бусад судлаачидын хамтарсан судалгааны ажил/. УБ 2013 он

---o0o---

